

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны 8 дугаар тэмдэглэлд:

“ХҮ.3. “Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн авто замын Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто замыг барьж байгуулах төслийн концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан “Чингис лэнд девелопмент групп-Шинэ хөгжлийн зам” ХХК-тай байгуулсан “Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам” төслийн концессын гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлүүд биелсэн эсэхэд хийсэн дүгнэлт болон хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу тодорхой тооцоо, судалгаа бүхий дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэж, холбогдох шийдвэрийн төслийн хамт Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан)-т даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР